

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1 Оршил	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа хууль эрх зүйн орчин	5
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	6
2.9.1 Мөнгөн хөрөнгө.....	6
2.9.2 Авлага	7
2.9.3 Бараа материал.....	7
2.9.4 Үндсэн хөрөнгө	8
2.9.5 Өр төлбөр	9
2.9.6 Засгийн газрын хувь оролцоо	9
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.12 Шилэн дансны мэдээлэл	10
2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал.....	11
3.1 Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал.....	11
3.2 Авлагатай холбоотой асуудал	11
3.3 Харьяа байгууллагууд тай холбоотой.....	12
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	17
5. Хавсралт.....	18
5.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УЦУОШТ	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА С.ЭНХТҮВШИН
ТАНАА

20 20. 03. 25 № 01/928
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.ТЭНГИС

2. Аудитын тайлан

2.1 Оршил

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч С.Энхтүвшин Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Цаг уур, орчны шинжилгээний газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 3 дугаар сарын 13-наас 2020 оны 3 дугаар сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Болормаа, аудитор Э.Энхбаатар нар гүйцэтгэв.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 01/118 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа хууль эрх зүйн орчин

Цаг уур, орчны шинжилгээний газар эрхэм зорилгоо “Ус, цаг агаар, байгаль орчны төлөв байдалд байнгын хяналт шинжилгээ хийж, бодит болон урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн болзошгүй гамшгийн эрсдэлээс сэрэмжлүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

Цаг уур, орчны шинжилгээний газар үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Монгол улсын хэмжээнд ус цаг уур, байгаль орчны төлөв байдал чанарын хяналт шинжилгээг зохион байгуулж, хэрэглэгчийг мэдээллээр шуурхай хангах, ус, цаг агаарын аюултай үзэгдлийн улмаас үүсч болзошгүй гамшгийн эрсдэлээс эртнээс сэрэмжлүүлэх;
- Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг нэгдсэн удирдлага, нэгдмэл арга зүйгээр хангах, өргөжүүлэх, чадавхийг бэхжүүлэх;
- Ус цаг уур, байгаль орчны чанарын хяналт шинжилгээний улсын сүлжээний үйл ажиллагааг тасралтгүй явуулж, мэдээлэл цуглуулах, түүнийг хэрэглэгчдэд шуурхай хүргэх техникийн найдвартай ажиллагааг хангах, техник технологийн байнгын шинэчлэл хийх;
- Ус, цаг уур, байгаль орчны архив, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх ажлыг удирдан зохион байгуулах, хэрэглэгчдийг мэдээллээр үйлчлэх.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Цаг уур, орчны шинжилгээний газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Цаг уур, орчны шинжилгээний газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Цаг уур, орчны шинжилгээний газрын Захиргаа, аудитын хэлтэс 2019 онд харьяа орон нутаг дахь 6 газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 2 зөвлөмж өгч ажилласан байна.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Цаг уур, орчны шинжилгээний газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 13 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 27,581.6 сая төгрөгийн 1 хувь буюу 275.8 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 26 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс аудитад 18, аудитын түүвэрт 4 байгууллага хамрагдаж, 4 байгууллагад итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа бүх байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 3.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 1.8 сая төгрөгийн алдааг залруулж, 1.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж, харьяа байгууллагуудад нийт 335.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 172.8 сая төгрөгийн алдааг залруулж, 7.8 сая төгрөгийн 8 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 23.6 сая төгрөгийн 6 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 131.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 27 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа 3 байгууллагын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулсан.

2.9 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2.9.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 9.0 сая, эцсийн үлдэгдэл 15.6 сая төгрөг болж, 6.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 1 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	9.0	15.6	6.6
Дүн	9.0	15.6	6.6

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 15.6 сая төгрөг төрийн сангийн нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

Архангай, Баян-өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Сүхбаатар, Увс, Ховд аймгийн УЦУОШТ-үүдэд мөнгөн хөрөнгөтэй холбоотой нийт 16.4 сая төгрөгийн дараах зөрчлүүд байна. Тухайлбал:

- Үр дүнгийн урамшуулал, ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг давхардуулан олгосон;
- Албан томилолтоор ажилласан хүнд хоолны мөнгийг давхардуулан олгосон;
- Нотлох баримтгүйгээр илүү цагийн хөлсийг бодож олгосон;
- Цалингийн суутгалыг илүү, дутуу тооцсон;
- Давсан орлогыг үйл ажиллагааны зардалд зөвшөөрөлгүй зарцуулсан;

- Анхан шатны баримтын бүрдэл дутуу, гарын үсгээр баталгаажуулаагүй ажил гүйлгээг бүртгэсэн зэрэг зөрчлүүд байна.

2.9.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 26.0 сая, эцсийн үлдэгдэл 65.8 сая төгрөг болж, 39.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	1.6	0.9	(0.7)
Төлбөртэй үйлчилгээний авлага	0.2	0.2	-
Татаас, санхүүжилтийн авлага	19.4	59.4	40.1
Байгууллагаас авах авлага	1.2	2.6	1.3
Хувь хүнээс авах авлага	3.6	2.7	(0.9)
Дүн	26.0	65.8	39.8

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 2.2 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Баянхонгор аймгийн УЦУОШТ-ийн 2013 онд үүссэн нэр бүхий иргэнтэй холбоотой 0.8 сая төгрөг;
- Орхон аймгийн УЦУОШТ-ийн 1999 онд дампуурсан Сэргээн босголтын банктай холбоотой 0.2 сая төгрөг;
- Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа “Хурын шим” төвд Аянга ХХК 1992 онд мөндрийн сум нийлүүлэх гэрээ байгуулж 1.2 сая төгрөгийг шилжүүлэн авсан боловч бараа нийлүүлээгүйгээс үүссэн авлага байна.

Аудитын илрүүлэлт:

Баянхонгор, Дундговь аймгийн УЦУОШТ-үүдэд авлагатай холбоотой 2.7 сая төгрөгийн дараах зөрчил гарсан байна. Үүнд:

- 2013 онд үүссэн нэр бүхий иргэнтэй холбоотой 0.8 сая төгрөг;
- Шүүхийн шийдвэрээр олгосон 1.9 сая төгрөгийн авлагыг тус тус барагдуулаагүй.

2.9.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 4,487.2 сая, эцсийн үлдэгдэл 5,293.3 сая төгрөг болж, 806.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 3 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	2,785.7	3,493.6	707.9
Эм боох материал	33.5	35.3	1.8
Дуусаагүй үйлдвэрлэл	21.2	21.2	-
Бэлэн бүтээгдэхүүн	3.5	2.5	(1.0)
Бичиг хэргийн материал	95.1	86.5	(8.6)
Аж ахуйн материал	491.0	513.8	22.8
Сэлбэг хэрэгсэл	491.6	578.4	86.8
Түлш, шатах тослох материал	51.8	50.9	(0.9)
Барилгын засварын материал	18.5	17.9	(0.6)
Бусад хангамжийн материал	467.3	465.2	(2.1)
Мал амьтад	28.0	28.0	-
Дүн	4,487.2	5,293.3	806.1

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд бараа материал төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 2,878.9 сая, хандиваар 3.7 сая, Цаг уур, орчны шинжилгээний газраас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 1,226.1 сая, дотоод гүйлгээгээр үндсэн хөрөнгөөс бараа материалд шилжүүлсэн 575.6 сая төгрөгөөр нэмэгдсэн, шинжилгээ судалгааны ажилд зарцуулсан 2,010.2 сая, Цаг уур, орчны шинжилгээний газраас харьяа байгууллагуудад шилжүүлсэн 1,699.6 сая, акталсан 127.0 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

Дорноговь, Дорнод аймгийн УЦУОШТ-үүдэд бараа материалтай холбоотой нийт 15.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтаар ирсэн Samsung маркын принтерийг аж ахуйн материалаар орлогодож зарлага гаргасан;
- Бараа материалын худалдан авалтын 57 хувь буюу 15.1 сая төгрөгийн анхан шатны баримтад Е-баримтыг хавсаргаагүй.

2.9.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө цэвэр дүнгээр эхний үлдэгдэл 21,958.4 сая, эцсийн үлдэгдэл 21,273.8 сая төгрөг болж, 684.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	9,310.0	9,139.6	(170.4)
Авто-тээврийн хэрэгсэл	416.1	271.7	(144.4)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	3,079.2	2,850.7	(228.5)
Тавилга, аж ахуйн эд хогшил	182.0	147.9	(34.1)
Зам, гүүрийн байгууламж	1.9	-	(1.9)
Бусад үндсэн хөрөнгө	175.4	152.1	(23.3)
Ном	16.0	3.3	(12.7)
Програм хангамж	78.4	73.6	(4.8)
Бусад биет бус хөрөнгө	8,699.4	8,634.9	(64.5)
Дүн	21,958.4	21,273.8	(684.6)

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 257.8 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 1,043.0 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 99.8 сая төгрөгөөр нэмэгдсэн, балансаас балансад шилжүүлсэн 665.2 сая, акталсан 230.9 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Сүхбаатар, Увс, Ховд аймгийн УЦУОШТ-үүд, Ус, цаг уур, орчны шинжилгээний хүрээлэнгүүдэд үндсэн хөрөнгөтэй холбоотой нийт 20.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/485 тушаалаар Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа байгууллагуудад хуваарилсан Mitsubishi Pick Up L200 автомашиныг хүлээн авсан боловч эрх бүхий байгууллагын тушаал шийдвэр гараагүй тул данс бүртгэлд тусгаагүй;
- Хөрөнгийн ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгүүдийг ангилан үнэлгээ тогтоох, акталсан хөрөнгийг устгал хийж данс бүртгэлээс хасаагүй;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тушаал шийдвэргүй хөрөнгө бэлтгэсэн;
- Үндсэн хөрөнгийн ангиллыг тодруулга тайланд буруу бүртгэсэн, бараа материалын дансанд бүртгэсэн зэрэг зөрчлүүд байна.

2.9.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 0.1 сая, эцсийн үлдэгдэл 3.3 сая төгрөг болж, 3.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн (+) Буурсан (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	-	3.3	3.3
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.1	-	(0.1)
Дүн	0.1	3.3	3.2

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 3.3 сая төгрөгийн ажилчидтай холбоотой өглөг байна.

Аудитын илрүүлэлт:

Баянхонгор аймгийн УЦУОШТ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар" журмын 3.6-ын б "Байгууллага олговол зохих цалингаас суутган төлөх төлбөрийг бусад өглөгт шилжүүлэн бүртгэнэ" гэсэн журмыг мөрдөөгүйгээс цалингаас суутгасан НДШ, ХХОАТ-аас бусад суутгалын 104.0 сая төгрөгийг "Бусад өглөг"-ийн дансаар бичилт хийлгүй "Цалингийн өглөг" дансанд бичилт хийсэн.

2.9.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 26,480.4 сая, эцсийн үлдэгдэл 26,645.2 сая төгрөг болж, 164.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн (+) Буурсан (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	25,670.9	25,670.9	-
Хуримтлагдсан үр дүн	(3,998.3)	(3,809.1)	189.2
Өмнөх үеийн үр дүн	(4,520.8)	(3,963.8)	557.0
Тайлант үеийн үр дүн	522.5	154.7	(367.8)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,807.8	4,783.4	(24.4)
Нийт дүн	26,480.4	26,645.2	164.8

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн залруулгад Баянхонгор, Булган, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Ховд аймгуудын УЦУОШТ 24.4 сая төгрөгийн үнэлгээтэй хөрөнгийг акталсан, Дорноговь аймгийн УЦУОШТ нь 2018 онд аймгийн Засаг даргын Тамгын газраас автомашин авахад дэмжлэг үзүүлсэн 10.0 сая төгрөгийг данс бүртгэлд тусгаагүй байсныг залруулсан байна.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 24,904.8 сая төгрөгийн төсвийн урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 24,834.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 69.9 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 24,758.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 76.5 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж, нийт 24,834.9 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 92.0 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 22.1 сая төгрөгөөр давсан нь Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн шинжилгээний орлого, Нислэгийн цаг уурын төв, Цаг уур, орчны шинжилгээний газруудын цаг агаарын мэдээний орлого нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 24,850.4 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 01/836 дугаар албан бичгээр төсөвт зохицуулалт хийснээс шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: Хандив тусламжаар 23 байгууллага, аж ахуйн нэгжээс 783.0 сая, Засгийн газрын нөөц сангаас 90.2 сая, дээд шатны төсвийн захирагчаас 354.3 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 305.8 сая, нийт 1,533.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 1,514.7 сая, хөрөнгийн зардалд 12.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Цаг уур, орчны шинжилгээний газрын худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулсан эсэхийг дараагийн аудитаар нарийвчлан үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Цаг уур, орчны шинжилгээний газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 139 мэдээллийг хугацаанд нь, 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Хөрөнгө зарцуулах тухай тушаал, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг гэх мэт мэдээллүүдийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн 1 албан шаардлага, 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Цаг уур, орчны шинжилгээний газрын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлснийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Цаг уур, орчны шинжилгээний газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Байгууллагын 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 2,187.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24 ажлаас 1,349.8 сая төгрөгийн 11 ажлын тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж дахин тендер зарлалгүй шууд гэрээ байгуулах зөвлөмжийг үнэлгээний хороо хүргүүлсэн, худалдан авах ажиллагаатай холбоотой баримт материалууд, тендерийн хавтас хэрэгт байх мэдээллүүдийг бүрэн оруулаагүй, архивын нэгж болгоогүй байна.

3.1.2 Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, холбогдох хууль тогтоомжийг зөрчих.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг 30 дугаар зүйлийн 30.4.1-д "тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах", 49 дүгээр зүйлийн 49.1-д "Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Авлагатай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Орхон аймгийн УЦУОШТ-ийн 0.2 сая, Цаг уур, орчны шинжилгээний газрын 1.2 сая, нийт 1.4 сая төгрөгийн 5-аас дээш жилийн насжилттай, эзэн холбогдогч нь тодорхойгүй, шүүхэд удаа дараа нэхэмжлэл гаргаад шийдвэрлээгүй авлага байна.

3.2.2 Эрсдэл:

Холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй байх, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг мөрдөж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3 ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДАЙ ХОЛБООТОЙ

3.3.1 Илрүүлэлт

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 335.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 172.8 сая төгрөгийн 18 алдааг залруулж, 7.8 сая төгрөгийн 8 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 23.6 сая төгрөгийн 6 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 131.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 27 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3.3.2 Эрсдэл

Холбогдох хууль тогтоомжийг зөрчих

3.3.3 Өгсөн зөвлөмж

Дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,522,166.3	5,374,699.3
МӨНГӨН ХӨРӨНГӨ	8,961.5	15,586.4
БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
АВЛАГА	26,041.1	65,849.8
УРЬДЧИЛГАА	-	-
БАРАА МАТЕРИАЛ	4,487,163.7	5,293,263.0
НӨӨЦИЙН БАРАА	-	-
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	21,958,352.6	21,273,819.0
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	21,958,352.6	21,273,819.0
Газар	-	-
Биет хөрөнгө	13,180,576.4	12,565,271.8
Биет бус хөрөнгө	8,777,776.2	8,708,547.2
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	26,480,518.9	26,648,518.3
НИЙТ ӨР ТӨЛБӨР	75.4	3,342.9
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	75.4	3,342.9
Өглөг	75.4	3,342.9
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	26,480,443.4	26,645,175.4
Засгийн газрын хувь оролцоо	26,480,443.4	26,645,175.4
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	25,670,935.4	25,670,935.4
Хуримтлагдсан үр дүн	-3,998,282.6	-3,809,082.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,807,790.6	4,783,322.6
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	26,480,518.9	26,648,518.3

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	29,410,989.3	27,736,357.7
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,725,902.0	1,299,907.2
Нийтлэг татварын бус орлого	5,725,902.0	1,299,907.2
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	23,685,087.3	26,436,450.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	27,887,024.0	27,480,776.4
УРСГАЛ ЗАРДАЛ	27,887,024.0	27,480,776.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,559,075.0	27,029,489.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,389,884.6	18,618,197.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,978,266.3	2,298,849.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	740,632.9	778,876.8
Хангамж, бараа материалын зардал	687,010.4	765,595.0
Нормативт зардал	40,004.8	23,491.8
Эд хогшил, урсгал засварын зардал	3,061,506.0	536,970.8
Томилолт, зочны зардал	194,949.6	230,870.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,236,514.7	1,075,014.8
Бараа үйлчилгээний бусад зардал	3,230,305.6	2,701,622.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	327,949.0	451,286.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,523,965.3	255,581.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,001,488.1	100,849.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	522,477.2	154,732.0

4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	23,822,759.8	26,572,507.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	86,069.2	92,025.6
Нийтлэг татварын бус орлого	86,069.2	92,025.6
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	23,736,690.6	26,480,481.4
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,606,473.4	26,308,067.0
УРСГАЛ ЗАРДАЛ	23,606,473.4	26,308,067.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,222,592.4	25,813,045.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,391,005.6	18,555,970.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,959,338.5	2,320,833.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	742,802.2	773,914.8
Хангамж, бараа материалын зардал	454,607.8	487,187.1
Нормативт зардал	60,112.0	40,280.2
Эд хогшил, урсгал засварын зардал	2,300,046.3	2,083,294.4
Томилолт, зочны зардал	204,451.4	233,671.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	953,270.2	1,104,934.3
Бараа үйлчилгээний бусад зардал	156,958.5	212,959.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	383,881.0	495,021.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	216,286.3	264,439.9
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	218,504.7	257,815.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	218,504.7	257,815.0
Дотоод эх үүсвэрээр	218,504.7	257,815.0
Гадаад эх үүсвэрээр	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-218,504.7	-257,815.00
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-2,218.4	6,624.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11,179.9	8,961.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,961.5	15,586.4

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,924,568.2	-	13,924,568.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,169.1	-	1,169.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,925,737.3	-	13,925,737.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	3,167,278.3	-	3,167,278.3
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	8,864,950.6	-	8,864,950.6
Тайлант үеийн үр дүн	522,477.2	-	522,477.2
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,480,443.4	-	26,480,443.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	34,468.0	-	34,468.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	26,514,911.5	-	26,514,911.5
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-24,468.0	-	-24,468.0
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-
Тайлант үеийн үр дүн	154,732.0	-	154,732.0
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,645,175.4	-	26,645,175.4

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	24,904,802.7	24,850,392.7	54,410.0	99.8
УРСГАЛ ЗАРДАЛ	24,904,802.7	24,850,392.7	54,410.0	99.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,647,237.1	24,634,314.1	12,923.0	99.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18,268,131.1	18,261,141.6	6,989.5	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,284,708.8	2,284,092.5	616.3	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	766,529.8	763,631.9	2,897.9	99.6
Хангамж, бараа материалын зардал	321,136.6	320,781.8	354.8	99.9
Нормативт зардал	35,504.8	35,424.6	80.2	99.8
Эд хогшил, урсгал засварын зардал	2,024,101.1	2,023,765.0	336.1	100.0
Томилолт, зочны зардал	132,550.9	132,494.9	56.0	100.0

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	683,824.6	682,254.8	1,569.8	99.8
Бараа үйлчилгээний бусад зардал	130,749.4	130,726.9	22.5	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	257,565.6	216,078.6	41,487.0	83.9
Бусад урсгал шилжүүлэг	257,565.6	216,078.6	41,487.0	83.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	24,904,802.7	24,850,392.7	54,410.0	99.8
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	24,834,872.7	24,758,367.1	76,505.6	99.7
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	69,930.0	92,025.6	-22,095.6	131.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	3,796	3,794	2	99.9
БАЙГУУЛЛАГЫН ТОО	26	26	0	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,885	1,884	1	99.9
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,885	1,884	1	99.9

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,526,673.5
УРСГАЛ ЗАРДАЛ	1,514,673.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,424,546.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	294,828.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,741.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,282.9
Хангамж, бараа материалын зардал	169,468.9
Нормативт зардал	4,855.6
Эд хогшил, урсгал засварын зардал	216,915.5
Томилолт, зочны зардал	101,176.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	508,044.7
Бараа үйлчилгээний бусад зардал	82,232.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90,126.9
Бусад урсгал шилжүүлэг	28,303.0
Олгосон санхүүжилт, шилжүүлэг	61,823.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,000.0
Дотоод эх үүсвэрээр	12,000.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,533,298.4
Нэмэлт санхүүжилтийн орлого	1,533,298.4
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	6,624.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,961.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,586.4

5. Хавсралт

5.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит	Аудитын код:
2020.03.24			САГ-2020/10/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Цаг уур, орчны шинжилгээний газар		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Байгууллагын 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 2,187.2 сая төгрөгийн батлагдсан төсөвтэй 24 ажлаас 1,349.8 сая төгрөгийн 11 ажлын тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж дахин тендер зарлалгүй шууд гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлсэн, худалдан авах ажиллагаатай холбоотой баримт материалууд нь задгай, тендерийн хавтас хэрэгт байх мэдээллүүдийг бүрэн оруулаагүй, архивын нэгж болгоогүй байна.	-	Зөвлөмж өгөх	Дарга Санхүү, төлөвлөлт, хамтын ажиллагааны хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	С.Энхтүвшин Б.Эрдэнэмөнх
2	Орхон аймгийн УЦУОШТ-ийн 0.2 сая, Цаг уур, орчны шинжилгээний газрын 1.2 сая, нийт 1.4 сая төгрөгийн 5-аас дээш жилийн насжилттай, эзэн холбогдогч нь тодорхойгүй, шүүхэд удаа даар нэхэмжлэл гаргаад шийдэгддэггүй авлага байна.	1.4	Зөвлөмж өгөх	Дарга Ахлах нягтлан бодогч	С.Энхтүвшин Д.Отгонбаяр
3	Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 335.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 172.8 сая төгрөгийн 18 алдааг залруулж, 7.8 сая төгрөгийн 8 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 23.6 сая төгрөгийн 6 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 131.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 27 зөвлөмжийг хүргүүлсэн байна.	162.8	Зөвлөмж өгөх	Дарга Ахлах нягтлан бодогч	С.Энхтүвшин Д.Отгонбаяр
	Дүн	164.2			

